

2024 он 03 сар 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2024 оны 4-р сарын 29-ний Даваа гарагийн 10:00 цагт** Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын ХААН театрт танхимын хэлбэрээр хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4-р сарын 10-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2024 оны 3-р сарын 22-ны өдөр хүргүүлэн, хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2024 оны 3-р сарын 25 болон 4-р сарын 9-ний өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2024 оны 3-р сарын 29-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг Хавсралт 1 ёсоор баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг Хавсралт 2 ёсоор баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт 3 ёсоор баталсугай.

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна компанийн шуудангийн хаягаар болон үнэт цаасны компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2024 оны 4-р сарын 26-ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг Хавсралт 4 ёсоор баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг Хавсралт 5 ёсоор баталсугай.

2024 он 03 сар 20 өдөр

Дугаар 12


Улаанбаатар хот

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, танилцуулах болон хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга /Б.Энхмандах/-д даалгасгай.

Комиссын дарга:	Тэргүүн дэд захирал	Б.Энхмандах
Гишүүд:	Хүний нөөц хариуцсан захирал	Д.Соёлмаа
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	ТУЗ-ийн мэргэжилтэн	Г.Дэмчигсэлмаа

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.ХУРАГАТСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Ц.ОРГИЛБОЛД

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, танилцуулах болон хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга /Б.Энхмандах/-д даалгасугай.

Комиссын дарга:	Тэргүүн дэд захирал	Б.Энхмандах
Гишүүд:	Хүний нөөц хариуцсан захирал	Д.Соёлмаа
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	ТУЗ-ийн мэргэжилтэн	Г.Дэмчигсэлмаа

ТУЗ-ИЙН ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

Б.АМАРСАЙХАН

Ц.ОРГИЛБОЛД


А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ


ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР




Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 он 03 сарын 20-ны өдрийн хурлын
12-р тогтоолын 1-р хавсралт




ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны ажлын тайланг танилцуулах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг батлах
7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон томилох



**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 3-р сарын 29-ний өдрөөс эхлэн дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354);
 - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
 - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
 - Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.




**ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

№	Агуулга	Хариуцсан албан тушаалтан	Хугацаа
1	Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх	Тооллогын комиссын дарга Н.Сайнзул	10:00-10:02
2	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	10:02-10:04
3	Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	10:04-10:06
4	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:		
	4.1 Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах	Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан	10:06-10:21
	4.2 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	10:21-10:23
	4.3 ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	10:23-10:30
	4.4 ТУЗ-ийн 2023 оны ажлын тайланг танилцуулах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	10:30-10:40
	4.5 ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төслийг танилцуулах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	10:40-10:45
	4.6 ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг танилцуулах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	10:45-10:50
	4.7 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	10:50-11:00
5	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	Хүн тус бүр 2 минут /Нийт 20 минут/	11:00-11:20
6	Санал өгөх зааварчилгаа танилцуулах	2 минут	11:20-11:22
7	Саналын хуудсаар санал авах	10 минут	11:22-11:32
8	Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/	20 минут	11:32-11:52
9	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	Тооллогын комиссын дарга Н.Сайнзул	11:52-11:55
10	Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	11:55-11:57
11	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хаах	ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа	11:57-12:00

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



“ГОВЬ” ХК-ИЙН 2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хурлын өдөр: 2024 оны 04 сарын 29-ний өдөр

Эхлэх цаг: 10:00 цаг

Байршил: **ХААН театр**

(Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сүүл оффисын 1 давхар)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:	
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	
Хувьцаа эзэмшигчийн и-мэйл хаяг:	

1-р хэсэг. Санал хураах арга: **Энгийн арга**

№	Шийдвэр гаргаж, батлах асуудал	Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай				
2	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох	Цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай				
3	ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг батлах	2024 оны цалингийн төсвийг батлах тухай				

Энгийн аргаар санал өгөх заавар:

- Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓ эсвэл +) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол “Зөвшөөрсөн” гэсэн нүдэнд (✓ эсвэл +), татгалзсан бол “Татгалзсан” гэсэн нүдэнд (✓ эсвэл +), түдгэлзсэн бол Түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓ эсвэл +) тэмдэг тавина.
- Хэрэв та хэлэлцэж буй асуудлын шийдвэрийг татгалзсан саналтай байгаа бол “Таны өгөх санал” гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай байгаагаа бичнэ.
- Засварласан, балласан, (✓ эсвэл +)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн, нэгээс олон санал бөглөсөн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2-р хэсэг. Санал хураах арга: Кумулятив арга

Нийт кумулятив саналын тоо:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
1	Дамбын ГЭРЭЛМАА	
2	Алтангэрэлийн ЖАРГАЛМАА	
3	Дамбийжавын ХҮРЭЛБААТАР	

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох

№	Нэр дэвшигчийн овог, нэр	Кумулятив саналын тоо
1	Баатарсайханы АМАРСАЙХАН	
2	Цагаачийн БААТАРСАЙХАН	
3	Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД	
4	Дашдаваагийн ХУЛАН	
5	Нямаагийн МӨНХБАТ	
6	Энхтөрийн ПҮРЭВЛХАМ	

Кумулятив аргаар санал өгөх заавар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн 1 хувьцаа нь 9 кумулятив саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь нийт кумулятив саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Говь ХК-ийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн, 6 нь ердийн гишүүнд нэр дэвшиж байна. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 300 эрхээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 нэр дэвшигчид, 600 эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 нэр дэвшигчид тус тус дурын харьцаагаар хуваарилан өгч болно.

Санамж:

- Хэрэв та саналын хуудсаар урьдчилан саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцдаг үнэт цаасны компаниараа дамжуулан өгөх, компани дээр биечлэн ирж өгөх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, "Говь" ХК хаягаар 2024 оны 04 сарын 26-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
- Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, нотариатаар баталгаажуулсан байна.

2024 оны ... -р сарын ... -ны өдөр


Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Тооллогын комисс бөглөх хэсэг:

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм Үгүй

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:



/Хэвлэл мэдээллийн эх/

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3-р сарын 20-ны өдрийн 12 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралд оролцохыг урьж байна.

Хурлын өдөр: 2024 оны 04 сарын 29-ний өдөр, Даваа гараг

Эхлэх цаг: 10:00 цаг

Байршил: ХААН театр (Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1 давхар)

Хурлын хэлбэр: Танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2024 оны 4-р сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
- 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны ажлын тайланг танилцуулах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг батлах
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон томилох

Хурлын материалтай танилцах:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2024 оны 3-р сарын 29-ний өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

- Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354);
- Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
- Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
- Говь ХК-ийн төв байранд байрлах ТУЗ-ийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.

Урьдчилан санал өгөх:

Хуралд биечлэн оролцох боломжгүй, урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигч хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж өөрийн харилцдаг үнэт цаасны компаниараа дамжуулан өгөх, компани дээр биечлэн ирж өгөх эсвэл Говь ХК-ийн шуудангийн хаягаар **2024 оны 4-р сарын 26-ны өдрөөс өмнө** ирүүлнэ үү.

Жич: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл **2024 оны 4-р сарын 29-ний 09:00 цагт эхлэн 09:55 цагт дуусах** тул та бүхэн цагтаа цуглана уу.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс	Нэр	Утас	И-Мэйл
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ	9411-8277	boardoffice@gobi.mn
ТУЗ-ийн мэргэжилтэн	Г.Дэмчигсэлмаа	9499-5750	

Говь ХК-ийн албан ёсны хаяг:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081
Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК

2024 он 03 сар 20 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга: Н.Сайнзул – Ахлах аудитор
Нарийн бичгийн дарга: Ц.Цэцэгбадам – Үйлдвэр бүртгэлийн албаны дарга
Гишүүд: Б.Уянга – Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Д.Сарангуа – Аудитор
Б.Номин – Нягтлан бодогч
Б.Ууганзаяа – Нягтлан бодогч

Хоёр. Тооллогын комисс (Н.Сайнзул)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Хувьцаа эзэмшигчид цахим санал хураалтад оролцох бүртгэлийг хийх;
6. Саналын хуудсыг хайрцгаар мөн цахим хэлбэрээр авах;
7. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
8. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

ТУЗ-ИЙН ДАРГА:

“ГОВЬ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

Ц.БААТАРСАЙХАН

ТТН2998 ☎ 2076367

Б.АМАРСАЙХАН

Ц.ОРГИЛБОЛД

20~~24~~ он ~~03~~ сар ~~20~~ өдөр

Дугаар ~~13~~

Улаанбаатар хот




А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР



А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР